



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 407

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгч томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал зохих журмын дагуу томилогдох хүртэл захирлын үүргийг түр орлон гүйцэтгэх төрийн өмчийн төлөөлөгчөөр Б.Болортуяа (Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)-г 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэх төрийн өмчийн төлөөлөгч Б.Болортуяатай зохих журмын дагуу ажил хүлээлцүүлэхийг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ